



“ЭРДЭНЭДРИЙЛИНГ” ХХК-Д

“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

21065. Чойбалсан, Дорнод аймаг
Утас/ факс: 7058-4545
E-mail: info@ees.energy.mn

2020. 02. 21 № 1/131

танай 2020.02.19-ны № 20/038 -Т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

2020 оны 2 дугаар сарын 19-ны өдөр “Эрдэнэдрийлинг” ХХК-ны ирүүлсэн ДБЭХС/202001031 дугаарт тендерийн “гүний худгийн цооног гаргах, гүний усны судалгаа хийх, гүний усны төвшин хэмжигч логер суурилуулах” ажлын ажлын даалгаврын 11-т тусгагдсан “цооногуудад гүний усны судалгаа хийж дүгнэлт гаргах” гэсэн ойлголтонд дараах ажилбарууд багтана. Үүнд:

1. Хайгуул судалгааны ажил гүйцэтгэх арга, аргачлалыг тодорхойлох. /Ажлын хэмжээ, хийх ажлын дараалал гэх мэт/
2. Судалгааны талбайн геологи-гидрогеологийн өмнөх судлагдсан байдалтай танилцах.
3. Талбайд геологи-гидрогеологийн маршрут хийж талбайтай танилцах, хээрийн мэдээлэл цуглуулах /дээжлэлт, хэмжилт, усны түвшин гэх мэт/
4. Шавхалт туршилтын ажлыг 3-4 цооногт гүйцэтгэх/48-72 цагийн усны түвшин бууралт, ундаргын хамаарлыг тодорхойлох/
5. Газрын доорх усны дээжлэлтийг цооноогоос авч үр дүнг тодорхойлох
6. Газрын доорх усны горимийн судалгаа буюу усны түвшиний хэмжилтийн ажлыг хийж гүйцэтгэх.
7. Шавхалтын ажлын үр дүнгээр гидрогеологийн үндсэн параметруудийг тодорхойлох.
8. Газрын доорх усны ашиглалтын нөөцийн үнэлгээг тооцоолох.
9. Хайгуул, судалгааны ажлын үр дүнгийн тайланг бичиж захиалагчид танилцуулж, хүлээлгэн өгөх.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Г.ОТГОНБААТАР